

Дэлхийн БНСУ-

Агуулга

1. Таницуулга
2. Түүх
3. Эдийн засгийн өсөлт
4. Ардчиллын тунхаглал
5. Дэлхийн тавцан дах Солонгос

1. Таницуулга

Өмнөд солонгос нь азийн зүүн хязгаар Солонгосын хойгийн урд талд оршино. Умард Солонгостой хуурай газраар хиллэн, баруун талаараа Шар тэнгис, Японы тал болох зүүн талаар Зүүн тэнгисээр хүрээлэгдэнэ.

Ерөнхий мэдээлэл

- Албан ёсны нэршил: Бүгд Найрамдах Солонгос Улс
- Байрлал: Хойд өргөргийн 33° — 39°, зүүн уртрагийн 126°
- Нутаг дэсгэр: 100.266 км² (2013)
- Нийслэл: Сөүл (9.926.000) (2013)
- Хүн ам: 50.220.000 (2013)
- Хүн амын нягтшрал — 501 хүн/км²
- Хэл: Солонгос хэл (бичих систем: хангыл)
- Шашин шүтлэг: Хүн амын 22.8% нь будда, 18.3% нь христ, 10.9% нь католик, 1.1% нь бусад, 46% нь шашин шүтдэггүй
- Засаглал: ерөнхийлөгчийн засаглалтай, ардчилсан улс
- Дундаж температур: -2.5 °C (нэгдүгээр сард), +25.4 °C (найм дугаар сард)
- Үндэсний далбаа: тэйгигки
- Үндэсний бэлгэдэл цэцэг: Мүгинхуа (шарон сарнай)

Эдийн засаг

- ДНБ (дундаж): US \$1,417 сая (2014)
- ДНБ нэг хүнд ногдох (дундаж): US \$28,101 (2014)
- ДНБ (валютын худалдан авах чадвар) (дундаж): US \$1,779 (2014)
- ДНБ нэг хүнд ногдох: US \$35,277 (2014)
- ҮНО (дундаж): US \$1,366 сая (2014)
- ҮНО нэг хүнд ногдох (дундаж): US \$27,090 (2014)
- ҮНО (валютын худалдан авах чадвар) (дундаж): US \$1,746 (2014)
- ҮНО нэг хүнд ногдох (дундаж): US \$33,620 (2014)
- Экспорт: US \$573 тэрбум (2014)
- Импорт: US \$526 тэрбум (2014)
- НТЭ :31,1 (2011)
- ХХИ хүний хөгжлийн индекс :0,891 (15-рт) (2013)
- Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн: хагас дамжуулагч, авто машин, усан онгоц, цахилгаан бараа, гар утас, ган
- Мөнгөн тэмдэгт: Вонь (KRW Бүгд Найрамдах Солонгос Улс вон) (US 1\$=1,060 вонь) (2014)

2. Түүх

ЭРТНИЙ СОЛОНГОС УЛС

Чулуун зэвсгийн үеэс Солонгосын хойг, орчин тойрны газар нутагт хүмүүс амьдарч эхэлжээ. Хүрэл зэвсгийн үед ГоЧусон аймгийн хүмүүс анхны төрт улсыг байгуулжээ. Солонгосчууд "Эцэг өвөг Дангун"-ыг ГоЧусоныг үндэслэгч хэмээн дээдэлдэг. Эртний домогт өгүүлснээр Дангун нь баавгайн овгийн бурханы хүү ажээ. Хуанун нь газарт амьдрахаар ирсэн тэнгэр гаралтан аж. ГоЧусон нь тухайн үедээ хойд солонгосын газар нутгаг байсан бөгөөд одоогийн Манжуурын тал юм. МЭӨ 108 онд Хан гүрэн ГоЧусон аймгийг довтолгох хүртэл урт хугацааны турш оршин тогтнож байсан юм.

ГУРВАН УЛС

7-р зуунд хойд хэсэгт Гугурё, баруун өмнөд хэсэгт Пэгжэ, зүүн өмнө хэсэгт Шилла зэрэг улс үүсч, улс төрийн эдрээтэй бүтэц бүхий овгийн холбооны улс болон нэгдэн хаант улс тогтножээ. 8-р зууны дундуур Шилла улс орчин тойрондоо байх Гаяа улсыг нэгтгэн улсыг бүтэн хэмжээнд захирдаг болов. Шиллагийн ноёрхол 10-р зууныг хүртэл тогтвортой байсан ч 935 онд улс төрийн уналтанд орж шинэ Гурёо улсад арга буюу дагаар оржээ. Шиллагийн хүчирхэг үед шашин соёл урлаг, уран зохиолын сан хөмрөг нь арвижжээ.

Солонгосын шашин шүтлэг

372 онд Хятадын нөлөөллөөр буддын шашин дэлгэрч ард түмний соёл уламжлалд гүн шингэжээ. Буддын шашин нь гурван улсын үеэс эхлэн Гурёогийн хаант улсын засаглал хүртэл үндэсний шашин байсан. Чусон гүрний үед 1398-1910 Күнзийн суртал төр засгийн суурь зарчим болжээ..

18-р зууны үед католигийн шашин, 19-р зуунд протестант урсгал орж ирсэн. Анхандаа, засгийн газраас христийн шашинг эсэргүүцэж байсан ч 19-20 зуунд христ итгэгчид олширч өнөөдөр хүн амын 30 орчин хувь нь христ итгэлтэй ч Буддын шашин өнөөдрийг хүртэл оршин байна. Мөн күнзийн сургаал Солонгосын нийгмийн хэм хэмжээ, бизнесийн ёс зүйд нөлөөтэй номлол болсон.

ГУРЁО БОЛОН ЖУСОН

< Гурёо >

935 онд Гурёо хаант улс Шилла гүрнийг дагаар оруулан улам бүр хүчирхэгжсэн. Гурёо үндэсний шашнаараа Буддын шашиныг сонгосон бөгөөд энэ үед хэд хэдэн Буддын түүхэн бүтээл туурвигдажээ. Гурёо хаант засаглал нь гадаад харилцаа бодлогын хувьд нээлттэй байсан. Тиймээс ч Гурёо гадаад улсуудад "Корио"

хэмээн танигджээ. Гурёо гүрэн 470 жил 14-р зууны сүүлээр Жусон гүрэн мандан бадрах хүртэл оршин тогтножээ.

Трипитака Кориана

Трипитака Кориана бол буддын сургаалыг барлан сийлсэн дэлхийн анхны модон бар ажээ. 81,258 модон дээр сийлбэрлэсэн энэ түүхийн агуу өв нь 13-р зуунд Курёо гүрний үед бүтээгдсэн бөгөөд тухайн үед дэлхийг эзэлж байсан Монголчуудын халдлагаас Буддын шашны сургаалыг хадгалан үлдэх оролдлого байжээ. Хавтан хоёр талдаа 320 хятад ханз үсгийг багтаасан бөгөөд нийт 52 сая дүрс үсэг нягт нямбай сийлэгджээ. Эдгээр бичвэрт ганц ч алдаа байхгүй нь гайхалтай.

< Чигжи >

Курёо буюу Гуулин улсын үед суурин соёл урлаг, эрдэм сэнхүүрэл, түүхэн өв соёл их бүтээжээ. Тухайлбал 1377 оны буддын «Чигжи» судар. Энэ нь хураангуйлан бичсэн Буддын шашны сургаал номлол. «Чигжи» дэлхийн хамгийн эртний номонд тооцогддог бөгөөд анхны төмөр бар юм. Чигжи нь хамгийн анхны хэвлэл гэгдэх Иоханаас Гутенбергийн 42 мөрт Библиэс 78 жилийн өмнө буюу 1450 онд хэвлэгдэж байсан түүхийн үнэт олдвор юм. Өдгөө Чигжиг Францын үндэсний номын сангийн түүхэн үнэт гар бичмэлийн хэсэгт хадгалагдаж байна. 2001 онд ЮНЕСКО дэлхийн үнэт дурсгалт бичээсээр бүртгэсэн.

< Чусонь >

Чусонь гүрэн 1392 онд хүчирхэгжин солонгосын хойгийг 500 жилийн турш захирчээ. Күнзийн номлолд үндэслэсэн үзэл суртлыг бий болгосон. Чусонь гүрний үед Солонгосын Хангыл цагаан толгой зохиогдсон.

Хангыл: Солонгос үсэг

1443 онд Чусоны И Сэжун хаан солонгос хэлийг тэмдэглэх авианы бичиг үсэг зохиосон юм. Энэ цагаан толгой нь төвөгтэй хятад ханзыг орлож энгийн иргэдэд чөлөөтэй уншиж бичих боломжийг олгожээ. Тэмдэг үсгүүд нь эгшиг гийгүүлэгч авиаг бүрэн илэрхийлдэг учраас хэдхэн цаг хичээллэхэд л уншиж бичиж сурахуйц хялбар цагаан толгой юм. Тиймээс хангыл үсэг нь шинжлэх ухааны талаас шилдэг хэлний нэгд зүй ёсоор тооцогддог.

ХОЙГИЙН ХУВААГДАЛ

< 3-р сарын 1-ний бослого >

Орчин үеийн хувьсгалын эхлэл солонгосын хойгийг тойроогүй. Имприализм 1910 онд Япон цэргийн хүчээр Солонгосын газар нутагт түрэмгийлэн оржээ. Японы

дарангуйлалыг тэсвэрлэх аргагүйд хүрсэн Солонгосчууд 1919 оны 3-р сарын 1-нд бослого гарган тусгаар тогтнолоо тунхаглажээ. Солонгосчууд бүрэн эрхээ буцаан авахын тулд ил далд тэмцэж улс төрийн болон цэргийн хүчний эсэргүүцэл дотоод гадаадад бий болжээ. Солонгосын түр засгийн газар Шанхайд байгуулагджээ.

< Чөлөөлөх дайн >

Дэлхийн 2-р дайн дуусмагц 1945 онд Японы колончлол ч Солонгосын хойгоос арчигдав. Эрчимтэй гүнзгийрч байсан хүйтэн дайны уршгаар Солонгос улс 38-р өргөргөөр хоёр хуваагдаж Өмнөд болон Хойд Солонгос өөр өөрийн Засгийн газраа байгуулав. 1948 оны 8 сарын 15-нд, хойгийн хойд хагас “Умард солонгос” хэмээн нэрлэгдэх болж чөлөөт эдийн засагтай тусгаар улс болсноо зарлажээ. Харин солонгосын хойгийн өмнөд хагас АНУ-ын цэргийн хяналтанд байж, капиталист (хөрөнгөт) эдийн засаг, ардчилсан дэглэмээр замнахад бэлтгэгджээ. Хойд солонгост ардчилсан нам үүсэн Зөвлөлтийн дэмжлэгтэй Ким Ил Сон улс төрийн удирдлагыг гартаа авчээ.

Ийнхүү хуваагдсаны дараахан Хойд солонгос Зөвлөлтийн цэргийн хүчний тусламжтай 1950 оны 6 сарын 25-ны өдөр 38-р өргөргийг давж солонгосын иргэний дайн эхэлсэн юм. Гурван өдрийн дотор Сөүлд Хойд солонгосын цэргийн хүч халдан 8-р сар гэхэд далайн эргийн Бусанаас бусад бүх хотод халдан эзэлсэн байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын аюулгүйн зөвлөл шуурхай хуралдаан хийж харьяа 21 гишүүн улс Өмнөд солонгост туслах гэрээнд гарын үсэг зурж, цэргийн хүч болон тусламжийн бараа илгээжээ. Дуглас Мак Артур 9 сарын 15-нд агаараар довтолж Америкийн болон Нэгдсэн Үндэсний цэргүүд хүч хавсран Хойд солонгосын цэргийг хятадын хил хүртэл ухрааж чадсан тухайгаа өгүүлжээ.

Өмнөд солонгосын цэрэг Нэгдсэн Үндэсний цэрэг дийлэнх нь америкийн цэргээс бүрдсэн солонгосын арми Хойд солонгосыг 38-р өргөрөг хүртэл ухраажчадсан. Дайны өмнө, Америкийн Нэгдсэн Улс болон хуучин ЗХУ 38 дахь өргөргийн дагуу хил тогтоосон байна.

Ингэж улс орон үймээн самуунд автаж урт удаан дайн завсарласан юм. Энэ дайны үеэр японы колоний үеэс үлдсэн барилга байгууламжубүхэлдээ үнс нурам болжээ.

Дайны дараа өмнө нь хэлэлцээрийн дагуу тогтоож байсан хилийн заагийг(MDL) шинэчлэн хоёр солонгосын хилийн бүсэд байрладаг 4 км цэрэггүй бүс (DMZ) бий болгосон.

Өмнөд солонгосын хүн ам 50 сая орчим, БНАСУ нь 25 сая хүн амтай.

3. Эдийн засгийн өсөлт

1960 онд генерал Пак Жон Хи цэргийн хүчээр төрийн эрхийг авч 1979 он хүртэл ерөнхийлөгч байв. Түүний үед цэргийн дарангуй дэглэмтэй ч эдийн засаг экспортод чиглэн үсрэнгүй хөгжсөн. Пак Жон Хи ЗХУ-ын загвараар 5 жил тутмын макро эдийн засгийн "Хан мөрний гайхамшиг" төсөл хэрэгжүүлж эдийн засгийн шинэ эргэлт хийжээ. 1980-1990 онд нэхмэл, даавуу, гутлын экспортоос илүү автомашин, электроник, усан онгоц, ган үйлдвэрлэж, экспортлох болжээ. 1962 оноос огцом хөгжиж, 40 жил хүрэхгүй хугацаанд "Хан мөрний гайхамшиг" хэмээх гялалзсан амжилтыг дэлхий нийтэд гайхуулж чаджээ. Экспортыг хөгжлийн хөдөлгүүр болгон гадагш чиглэсэн эдийн засгийн хөгжлийн стратеги нь Солонгосын эдийн засгийн шинэчлэлд маш их хувь нэмэр оруулсан.

Солонгосын эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдал дэлхий дахинд танигдах болсон нь хэд хэдэн голлох бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсонтой нь холбоотой. 1960-1970 оны хооронд хөнгөн үйлдвэрийг засгийн газрын бодлогоор дэмжиж эхэлжээ. Мөн усан онгоц үйлдвэрлэл, өнгөт металл, төмөрлөгийн үйлдвэр, цахилгаан бараа зэрэг нь эдийн засгийн өсөлтөнд томоохон түлхэц үзүүлсэн юм.

1981 онд, Судалгаа хөгжлийн газрын үнэлснээр цахилгаан барааны экспорт нь 1980 оны сүүлчээр хүчээ авчээ. Экспортыг дэмжсэн бодлогын дор LG, Samsung, Hyundai нь дэлхийн томоохон экспортлогч компаниуд болж 1990 оныг хүртэл тэдний өсөлт эрчимтэй үргэлжилсэн.

1970 онд "СэйМайл буюу шинэ тосгон хөдөлгөөн"-ийг эхлүүлсэн бөгөөд энэ нь хамтын хөдөлмөрөөр сайн сайхан нийгмийг цогцлоох үйлсэд иргэд, тариаланчдыг татан оруулах зорилготой ажээ. "СэйМайл хөдөлгөөн" гэдэг нь -"Шинэ тосгон хөтөлбөр" гэсэн утгатай юм. Энэхүү төслийн хүрээнд тариаланчдын амьдрах орчинг хөгжүүлж орон нутгаа хөгжүүлсэн юм. Энэхүү төсөл нь солонгост амжилт олсон төдийгүй хэд хэдэн хөгжиж буй улсад хэрэгжиж хүрээгээ тэлсээр байгаа билээ.

Экспортын бодлогод түлхүү суурилсан Өмнөд Солонгос эдийн засгийн өсөлтийг гайхамшигтайгаар үзүүлсэн улс юм. Дэлхийн 2-р дайны дараа гадаадын тусламж авдаг орноос тусламж үзүүлдэг улс болсон цорын ганц улс орон юм. 2014 он гэхэд Өмнөд солонгос дэлхийн 5 дахь экспортлогч , 7 дахь импортлогч улс болон хөгжжээ.

ӨМНӨД СОЛОНГОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

БНСУ нь хүчтэй удирдагчтай, сайн бэлтгэгдсэн үзэл сурталтай чинхүү хүсэл эрмэлзэлтэй ажилчдын хүчийг хослуулан эдийн засгийн гайхам хурдацтай

өсөлтөд хүрсэн. Засгийн газрын томоохон бизнес эрхлэгчдийг дэмжин, экспортыг нэмэгдүүлж, шинэ үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого ч энэхүү хөгжилд түлхэц болсон билээ.

Күнзийн сургааль нь эрдэм мэдлэг эн тэргүүнд байх бөгөөд эцэг эх, өвөг дээдсээ хүндлэх үндсэн сургаалтай. Аж үйлдвэржилтийн эхэн үед ихэнх ажилчид бичиг үсэгт тайлагдсанаар чадваржуулах боломж болжээ.

Үүний зэрэгцээ эдийн засгийн нээлттэй бодлого нь улс орнуудтай хамтран гадаадын дэвшилтэт шилдэг техник технологийг байгууллага, ажиллах хүчид шингээж ажилласан.

Өмнөд Солонгосын хилийн чандад ажиллагсад эх орон руугаа хүч хөдөлмөрөөрөө олсон мөнгөйлгээнэ.

Тухайлбал, 1960-аад оны дунд үеэс 1970-аад оны сүүл хүртэл Баруун Германд уурхайчид, сувилагчдыг ажиллах хүчнээр нийлүүлэн, тэдний цалин нь засгийн газрын суурь хөрөнгө болж хүнд аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд нь томоохон хувь нэмэр оруулсан юм.

4. Ардчиллын тунхаглал

Өмнөд Солонгосын иргэд эрх чөлөөт ардчилсан улс болохын төлөө амь биеэ зориулан тэмцэж байв. 1960 онд генерал Пак Жон Хи цэргийн хүчээр төрийн эрхийг авсан. Үүний дараа 1993 онд иргэний засаглалд шилжиж чөлөөт сонгууль болжээ.

Өмнөд Солонгосын сонин телевизүүд засгийн газраас хараат бусаар хэвлэлийн эрх чөлөөтэйгөөр мэдээллийг дамжуулдаг. Интернет болон олон нийтийн сүлжээний чөлөөт хэрэглээтэй. Харилцаа холбоо нь Солонгосын аль ч нутагт хурдан шуурхай ажилладаг зэрэг давуу талуудтай юм.

Солонгосын эдийн засгийн асар хурдацтай хөгжлийг даган эрх чөлөөний хөдөлгөөн хүчээ авсан. Цэцэглэн хөгжлийн үр дүнд Өмнөд Солонгос Улс өнөөгийн ардчилалтай болсон. Гэсэн ч эдийн засгийн хурдацтай өсөлт, нийгэм эдийн засгийн тэгш бус байдлыг бий болгож байна.

5. Дэлхийн тавцан дах Солонгос

Солонгос зуун зууны туршид "нүүдэлчин хаант улс" гэж нэрлэгдэж ирсэн. Солонгосын хойгийн худалдаа наймаа болон нүүдэл нь эртний уламжлалт түүхтэй. Түүхийн сурвалжид соёлын нөлөөлөл болон иргэдийн шилжилт хөдөлгөөнд Хятадын овог аймгуудаас төдийгүй Арабын худалдаачид, Зүүн өмнөд азийн уугуул оршин суугчид ч солонгост ирж суурьшсан гэж тэмдэглэжээ. Шилла гүрний үеийн нийслэл болох Геонжу нь тухайн үедээ торгоны замын азиас европыг холбосон гол хот байжээ.

Сүүлийн жилүүдэд, дэлхий даяараа Өмнөд Солонгосыг сонирхон судалдаг болсон бөгөөд дэлхийн хаанаас ч солонгосын бараа бүтээгдхүүн, аж амьдрал, соёл урлагийг харах боломжтой. Солонгосын залуучууд утсаараа интернэт орчинд дэлхийтэй холбогдож, англи болон бусад хэлийг сонирхон судалж дэлхийд үнэлэгдсэн мэргэжилтэн болохыг тэмүүлж байна.

Өмнөд Солонгос нь дэлхийн хамгийн хурдан интернэттэй бөгөөд техник технологийн хөгжингүй орнуудын нэг юм. Орчин үеийн интернет нь түүхэн Торгоны замын сүлжээтэй дүйх юм.

Өндөр хөгжлийн электрон хурдтай өнөө үед солонгосчууд өөрийнхөө туршилга, үзэл бодлоо интернэт орчинд чөлөөтэй хуваалцаж харицаа холбоогоо тэлж байна.

Түүхийн туршид, соёл солилцооны хөтөлбөр улсын хоорондын харилцааны хамгийн чухал зүйл байдаг. Солонгосын дуу хөгжим, кино урлаг олон орны хүмүүсийн таашаалд хүрсэн ба Халлюу буюу солонгосын соёлын давлагаа гэж нэрлэгддэг. Солонгос ч гэсэн дэлхийн олон орны соёлоос суралцаж даган дуурайж байна.

СОЛОНГОСЫН ӨДӨР ТУТМЫН АМЬДРАЛ

Солонгосын үндэсний хувцасыг “Ханбуг” гэж нэрлэдэг бөгөөд үндэсний баяр, хуримын ёслолд өмсдөг. Ханбуг нь богино хантааз болон урт даашинзаас бүрдэнэ. Эрэгтэй хувцас нь том хантааз болон шагай болон таашаандаа уяатай сул өмд өмсгөлтэй. Солонгосын өдөр тутмын хоол нь будаа, шөл болон кимчинээс бүрддэг. Солонгосчууд савхаар хооллодог.

Солонгост уламжлалт халаалтын системийг “Ундул” гэдэг бөгөөд орчин үеийн барилгыг энэ аргаар халаадаг. Солонгосын хаана ч ийм байрны бүтэц зохион байгуулалтыг харж болно.

Солонгосын үндэсний тулааны урлаг болох Таеквондо нь дэлхий дахинд алдартай бөгөөд залуу үеийнхэн ч гэсэн хичээллэсээр байна.



**The Academic
Center for International Affairs,**

108th Research Complex(Munhyeong
Haogae-ro, Bundang-gu, Seongnam-

- Tel. (

- Fax. (

h